


БАТЛАВ

БАЙГАЛЬ ОРЧИНД, АЯЛ. Л
ЖУУ ЧЛАЛЫН САЙД


Н. УРТНАСАН



БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсэгт "... Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй ..." гэж тусгагдсан билээ.

Тус нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Монгол Улсын Их Хурал 2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" 2 дугаар тогтоэлыг баталсан.

Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө"-ний 3 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлд тусгагдсан, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхийг хангах талаарх зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулахаар тусгасан.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхийг бататгах нь төрийн үндсэн үүрэг юм.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн орон нутагтаа байгаль орчны салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд иргэдтэй хамгийн ойр харилцаж ажилладаг.

Иймд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга иргэний мэдэх эрхийг хангах зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хуульд оруулах шаардлага гарч байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

Хуулийн төслийг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь 1 зүйл, 3 хэсгээс бүрдэнэ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд газрын хэвлийн баялгийг ашиглахнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрх болон иргэний тус эрхийг аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга хангаж, иргэнд мэдээлэл өгөх асуудлыг тодорхой болгож тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, шийдвэрлэх саналын талаар

Хуулийн төсөл батлагдснаар Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхийг хамгаалах механизм бүрдэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, мөрдүүлэх ажил сайжирч төр, иргэний харилцаанд дэвшил гарна.

Тус хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар болон улсын төсөвт нэмэлт зардал үүсэхгүй.

Дөрөв.Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбоотойгоор Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.